

НҮБУАӨСК-Нэгдсэн үндэсний байгууллагын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц

Конвенцийн Бүлэг 2-т

Энэхүү конвенц болон конвенцийг хэрэгжүүлэгч нэгж болох талуудын бага хурлын шийдвэрүүдийн гол зорилго нь хүлэмжийн хийн ялгаралыг уур амьсгалын тогтолцоонд аюултай өөрчлөлт оруулахааргүй түвшинд тогтворжуулах юм.

Талуудын бага хурлыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд конвенцийн хүрээнд цаашид хийгдэх арга хэмжээг болон хэрхэн хэрэгжүүлэх арга замуудыг нарийн тодорхойлж өгдөг. Талуудын 3-р бага хурлаар гарсан Киотогийн протокол нь конвенцийг илүү хүчирхэгжүүлсэн бөгөөд цаашид хийх арга хэмжээнд нэмэлт суурь орчинг бий болгосон.

НҮБУАӨСК нь 1992 оны 6-р сарын 3-14-нд Рио Дэ Жанейро хотноо зохион байгуулагдсан НҮБ-ын байгаль орчин ба эдийн засгийн хөгжлийн бага хурлаар гаргасан олон улсын байгаль орчны гэрээ хэлэлцээр юм. Энэхүү хэлэлцээрийн гол зорилго нь агаар мандал дахь хүлэмжийн хийн нягтаршлыг уур амьсгалд ноцтой нөлөөлхөөргүй түвшинд тогтворжуулах юм.

Конвенцод орон тус бүрт тусгайлан хүлээлгэсэн хүлэмжийн хийг бууруулах үүрэг тусгагдаагүйгээс гадна албадан шахах механизм байхгүй юм. Ийм ч учраас конвенц нь олон улсын хэмжээнд үүрэг хүлээлгэсэн эрх зүйн баримт бичиг биш юм. Харин конвенцод цаашид хуулийн дагуу хүчин төгөлдөр протокол гаргах талаар тусгаж өгсөн байна. Үүний дагуу хийгдсэн гол протокол нь Киотогийн протокол бөгөөд конвенцоос ч илүү олонд танигдах болсон.

НҮБУАӨСК-д 1992 оны 5 сарын 9 нөөс эхэлж дэлхийн улс орнууд гарын үсэг зурж эхэлсэн бөгөөд 1994 оны 5 сарын 21-д хүчин төгөлдөр болсон байна. 2009 оны 12 сар гэхэд нийт 192 орон конвенцод нэгдэн орсон байна.

Конвенцод тусгасан талуудын хийх шаардлагатай эхний үүрэг бол хүлэмжийн хийн ялгарал болон ялгаралын бууралттай холбоотой үндэсний тооллогыг хийх. Энэхүү тооллого нь Киотогийн протоколын хавсралт нэгийн орнуудын 1990 оны суурь үзүүлэлтийг бүрдүүлэхэд ашиглагдах бөгөөд жил бүр тооллогыг шинэчлэн мэдүүлж байхаар болсон байна.

Конвенцийн үйл ажиллагааг зохицуулахаар НҮБ-д конвенцийн нарийн бичгийн газрыг бий болгосон бөгөөд Германы Бонн хотод албан газар нь байрлаж байна. 2006 оноос хойш нарийн бичгийн газрын даргаар Ево Дэ Боер ажиллаж байгаа бөгөөд 2009 онд зохион байгуулагдсан Копенгагены бага хурлын дараа огцрох өргөдлөө гаргасан байна. Конвенцийг 1994 онд хүчин төгөлдөр болсноос хойш жил бүр талуудын бага хурлыг зохион байгуулахаар болсон бөгөөд энэхүү хурлаар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд болон цаашид хийх шаардлагатай асуудлуудыг үнэлж дүгнэж байхаар болсон байна. 1997 онд Киото хотноо зохион байгуулагдсан талуудын 3-р бага хурлаар Киотогийн протоколыг гаргасан бөгөөд энэхүү протоколоор өндөр хөгжилтэй орнуудад хүлэмжийн хийн ялгаралаа бууруулах тоон үүрэг хүлээлгэсэн.

Хавсралт нэг, хавсралт 2-ын орнууд болон хөгжиж буй орнууд

Конвенцод нэгдэн орсон талуудыг дараах байдлаар ангилсан байна.

- Хавсралт нэгийн орнууд- аж үйлдвэржсэн орнууд болон, шилжилтийн эдийн засагтай орнууд
- Хавсралт 2-ын орнууд- хөгжиж буй орнуудад хөгжихөд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх өндөр хөгжилтэй орнууд
- Хөгжиж буй орнууд

Протоколыг батламжилсан хавсралт нэгийн орнууд хүлэмжийн хийн ялгаралаа 1990 оныхоо түвшинөөс тодорхой хувиар бууруулах тоон үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү үүргээ конвенцийн талуудын хүлээн зөвшөөрсөн механизмуудын тусламжтайгаар биелүүлэх боломжтой юм.

Хавсралт 2-ын орнууд нь хавсралт нэгийн орнууд доторх нэг хэсэг бүлэг улс бөгөөд 1992 онд шилжилтийн эдийн засаг гэсэн тодорхойлолттой байсан улс орнуудыг хасаад Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гишүүн орнууд юм.

Хөгжиж буй орнууд нь өндөр хөгжилтэй орнууд хангалттай техник технологи, санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй тохиолдолд ялгаралын түвшингөө бууруулах зайлшгүй шаардлага байхгүй юм. НҮБ/УАӨСК-д хөгжиж буй орнуудыг нэн яаралтай хүлэмжийн хийн ялгаралаа хязгаарлахаар тусгаагүй нь 3 шалтгаантай.

1. Хүлэмжийн хийн ялгарал нь аж үйлдвэрийн хөгжилтэй шууд холбоотой байдаг учраас хязгаарлалт нь хөгжиж буй орнуудын хөгжилд саад учруулж болзошгүй юм.
2. Хөгжиж буй орнууд нь бууруулсан хүлэмжийн хийгээ үүрэг хүлээсэн, үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй байгаа улс орнуудад зарах боломжтой юм.
3. Хөгжиж буй орнууд Хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах хөрөнгө оруулалтанд хавсралт 2-ын орнуудаас санхүү, техник технологийн дэмжлэг авах

Хөгжиж буй орнууд нь хангалттай хөгжилд хүрсэн гэж үзсэн үедээ сайн дураар хавсралт нэгд орж болно.

Конвенцод шүүмжлэлтэй ханддаг зарим хүмүүс хавсралт нэг болон хөгжиж буй орнууд гэж хуваасан нь шударга бус аль аль нь дангаараа хүлэмжийн хийн ялгаралаа бууруулах ёстой гэж үздэг. Зарим улс орнууд Конвенцын шаардлагыг биелүүлэхэд гарах зардал эдийн засагт нь дарамт учруулна гэж үзэж байна. Энэ бол тухайн үеийн ерөнхийлөгч Жорж Бушийн Киотогийн протоколыг батламжлуулахаар сенатдаа өргөн мэдүүлээгүйгийн нэг шалтгаан юм. Бусад зарим орнууд Киотогийн протоколыг даган мөрдөх зардал нь юу ч хийхгүй байх үед үүсэх үр дагаврын зардлаас бага байхыг тооцоолсон Стерны тайлан гэх мэт судалгаа хийхэд анхаарч байна.

Хавсралт нэгийн орнууд

Хавсралт нэгд 40 орон байгаа бөгөөд Европын холбоо ч мөн гишүүн юм. Эдгээр орнуудыг аж үйлдвэржсэн орнууд болон шилжилтийн эдийн засагтай орнууд гэж ангилж буй юм.

Австрали, Австри, Беларус, Белги, Булгар, Канад, Хровати, Чех, Дани, Истони, Финланд, Франц, Герман, Грек, Унгер, Исланд, Ирланд, Итали, Япон, Латви, Лехтенштейн, Литва, Люксембург, Монако, Голланд, Шинэ Зеланд, Норвег, Польш, Португаль, Румин, ОХУ, Словак, Словень, Испани, Швед, Шевцари, Турк, Украин, Английн нэгдсэн хаант улс, АНУ

Хавсралт 2-ын орнууд

Хавсралт 2-т 23 орон болон европын холбоо багтсан байгаагаас 2001 онд Турк улс шилжилтийн эдийн засагтай орны жагсаалтанд багтааж өгөхийг хүссэнээр хавсралт 2-оос гарсан байна. Эдгээр орнууд нь өндөр хөгжсөн гэсэн ангилалд багтаж хөгжиж буй орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн байна.

Австрали, Австр, Белги, Канад, Дани, Финланд, Франц, Герман, Грек, Исланд, Ирланд, Итали, Япон, Люксембург, Голланд, Шинэ Зеланд, Норвег, Португаль, Испани, Швед, Шевцар, Английн нэгдсэн хаант улс, АНУ

НҮБУАӨСК-ын талууд хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад нийтлэг боловч харилцан адилгүй үүрэг хариуцлагын зарчим баримтлахыг санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрсөн бөгөөд конвенцийн хавсралт нэгд орж хавсралт нэгийн гэх тодотголтой болсон өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн орнууд илүү их үүрэг хариуцлага хүлээхээр болсон байна.

1992 оны 9 сарын 8-д АНУ-ын ерөнхийлөгч Буш НҮБУАӨСК-ыг Сенатдаа батламжлуулахаар өргөн мэдүүлжээ. Гадаад харилцааны хороо 1992 оны 10 сарын 1-д хэлцээрийг баталж мэдүүлснээр 1992 оны 10 сарын 7-д сенатаас конвенцийг батламжлах зөвшөөрлийг гишүүдийн 2/3-ийн саналаар өгснөөр ерөнхийлөгч Буш 1992 оны 10 сарын 13-д батламжлах бичигт гарын үсэг зурж НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн газарт хүргүүлсэн байна. Конвенцод тусгасан шаардлага болох 50 орон батламжилж баримт бичгээ хүргүүлснээр 1994 оны 3 сарын 21-д НҮБУАӨСК хүчин төгөлдөр болжээ.

Талуудын бага хурал

Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш талуудын бага хурлыг жил бүр зохион байгуулахаар болсон бөгөөд хурлаар цаашид уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлэх алхамыг хэлцэн ярилцаж байхаар болсон байна. Мөн 1990 оны дунд үеэс эхлэн өндөр хөгжилтэй орнуудад хуулийн дагуу хүчин төгөлдөр хүлэмжийн хийн ялгаралаа бууруулах тоон үүрэг хүлээлгэхээр зөвшилцөж эхэлсэн бөгөөд 1997 онд Киотогийн протоколыг гаргасан байна. Киотогийн протоколыг гаргасны дараа түүнийг батламжилсан орнуудын уулзалтыг Киотогийн протокол хүчин төгөлдөр болсон 2005 оноос хойш конвенцийн талуудын бага хуралтай зэрэгцүүлэн зохион байгуулах болсон бөгөөд Киотогийн протоколыг батламжлаагүй конвенцод нэгдэн орсон орнууд протоколын талуудын уулзалтанд ажиглагчаар оролцохыг зөвшөөрсөн байна.

1995- Талуудын анхдугаар бага хурал, Берлиний мандат

Конвенцийн талуудын анхдугаар бага хурлыг 1995 оны хавар Германы Берлин хотноо зохион байгуулсан бөгөөд талуудын Конвенцийн дор хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхын талаарх асуудлуудыг хөндөн ярилцсан байна. Энэ нь ч хурлаас гаргасан берлиний мандат гэж нэрлэгддэг НҮБ-ын сайдуудын тунхаг бичигт тусгагдсан байна. Энэхүү мандатаар 2 жил дүн шинжилгээ үнэлгээ хийж далайцтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг гаргах үе шатыг эхлүүлсэн бөгөөд тухайн жагсаалтаас улс орнууд өөрсдийн эдийн засаг байгаль орчиндоо хамгийн тохирсон арга хэмжээг сонгож биелүүлэхээр болсон байна. Берлиний мандатаар нийтлэг боловч харилцан адилгүй үүрэг хариуцлагын зарчмыг баримталж хэдийгээр үүнээс 15 жилийн дараа шинээр аж үйлдвэржиж буй орнууд нь нийлээд дэлхийн хүлэмжийн хийн ялгаралын хамгийн том эх үүсвэрүүд болох нь харагдаж байсан ч хавсралт 1-ийн бус орнуудыг зайлшгүй баримтлах нэмэлт үүрэг хариуцлагаас чөлөөлсөн байна.

1996 Талуудын 2-р бага хурал, Шевцари, Женев

Талуудын 2-р бага хурал нь 1996 оны 7-р сард Шевцарийн Женев хотод зохион байгуулагдсан бөгөөд 1996 оны 7-р сарын 18-д сайд нарын тунхаглал гаргасан нь АНУ-ын дэлхий нийтийн хэрэг эрхлэх газрын дэд нарийн бичгийн дарга асан Тимоти Виртийн тавьсан АНУ-ын байр суурийг илэрхийлсэн саналуудыг голчлон тусгасан байна. Эдгээр нь:

- Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх шинжлэх ухааны баримт болгон уур амьсгалын өөрчлөлтийн засгийн газар хоорондын хорооны (IPCC 1995) 2 дахь үнэлгээг хүлээн зөвшөөрөх
- Уян хатан байдлыг эрхэмлэн нэг хэвийн нийтлэг бодлого баримтлахгүй байх
- Хуулийн дагуу албадан биелүүлэх хүлэмжийн хийг бууруулах дунд хугацааны зорилт дэвшүүлэх

1997 Талуудын 3-р бага хурал, Уур амьсгалын өөрчлөлтийн Киотогийн протокол

Талуудын 3-р бага хурал 1997 оны 12-р сард Японы Киото хотноо зохион байгуулагдсан бөгөөд эрчимтэй хэлцэсний дүнд Киотогийн протоколыг гаргасан байна. Ихэнх аж үйлдвэржсэн орнууд болон төв европын шилжилтийн эдийн засагтай орнууд эхний үүрэгт хугацаа болох 2008-2012 оны хооронд хүлэмжийн хийн ялгаралаа 1990 оны түвшинөөс дунджаар 6-8 хувь бууруулах хуулийн дагуу үүрэг хүлээхийг зөвшөөрсөн байна. Киотогийн протоколоор АНУ-ыг хүлэмжийн хийн ялгаралаа 1990 оны түвшинөөс 7 хувиар бууруулахаар заасан боловч Клинтон ч засгийн газар, Бушийн ч засгийн газар аль аль нь протоколыг батламжлуулахаар сенатдаа өргөн мэдүүлээгүйгийн дээр Бушийн засгийн газар 2001 онд протоколоос ил тодоор татгалзсан байна.

1998 Талуудын 4-р бага хурал, Буэнос Айрэс

Талуудын 4-р бага хурал нь 1998 оны 11-р сард Буэнос Айрэс хотноо зохион байгуулагдсан бөгөөд Киото хотод шийдвэрлэгдээгүй асуудлуудыг энэхүү хуралдаанаар эцэслэн шийдвэрлэнэ гэж найдаж байсан боловч тэдгээр асуудлууд нь хэцүү, нарийн төвөгтэй харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй байсан учраас хурлаас 2000 он гэхэд

Киотогийн протоколыг хэрэгжүүлэх механизмуудыг бий болгож хүчин чармайлтуудад ахиц авчрах 2 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан байна.

1999 Талуудын 5-р бага хурал, Бонн, Герман

Талуудын 5-р бага хурлыг 1999 оны 10 сарын 25-наас 11 сарын 5-ны өдөр Германы Бонн хотноо зохион байгуулсан бөгөөд техник талын уулзалт болсноос өөр онцлог чухал шийдвэрт хүрээгүй байна.

2000 Талуудын 6-р бага хурал, Хагиу хот, Голланд

Талуудын 6-р бага хурал 2000 оны 11 сарын 13-наас 25-ны хооронд Голландын Хагиу хотод зохион байгуулагдсан бөгөөд яриа хэлэлцээр нь түргэн зуурд улс төрийн томоохон асуудлууд дээр өндөр хэмжээнд харилцан тохиролцоонд хүрсэн үр дүнг авчирсан байна. Эдгээр зөвшилцөлд хүрч чадсан томоохон асуудлуудаас дурьдвал, АНУ хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах үүргээ биелүүлэхдээ ашиглахаар ой мод, газар тариалангийн газар зэрэг хүлэмжийн хийн шингээгч эх сурвалжуудыг карбоны кредит цуглуулахад ашиглахыг хүссэн санал дээр үүссэн зөрөлдөөн, үүрэг хүлээсэн орнууд үүргээ биелүүлээгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээн дээрх санал зөрөлдөөн, мөн хөгжиж байгаа орнууд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах болон хүлэмжийн хийн ялгаралаа хэмжих төлөвлөгөө боловсруулах үүргээ биелүүлэх болон боломжтой бол бууруулах арга хэмжээг авахад хэрхэн санхүүгийн дэмжлэг авч болох тал дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд гарч буй хүндрэлүүд зэрэг байв. Хэдийгээр АНУ болон европын зарим орнууд зөвшилцөлд хүрсэн байсан боловч талуудын 6-р бага хурал өндөрлөхөөс хэдхэн цагийн өмнө Англи болон Дани, Герман зэрэг орнууд толгойлон европын холбоо хүрээд байсан зөвшилцөлийг хүлээн зөвшөөрхөөс татгалзсанаар Хагиу дахь яриа хэлэлцээр нурсан байна. Талуудын 6-р бага хурлын ерөнхийлөгч Яан Пронк зөвшилцөлд дахин хүрнэ гэсэн найдвартайгаар 6-р бага хурлыг түр засарлуулсан байна. Үүний дараагаар 6-р бага хурлыг 2001 оны 7 сарын сүүлийн хагаст Германы Бонн хотноо үргэлжлүүлэх шийдвэр гарснаас гадна ээлжит 7-р бага хурлыг 2001 оны 10-11 сард Марокко улсын Марракеш хотноо зохион байгуулахаар болсон байна.

2001 он Талуудын 6-р бага хурал Бонн, Герман

Талуудын 6-р бага хурал 2001 оны 7 сарын 17-27-нд Германы Бонн хотноо үргэлжилсэн боловч Хагиуд зөвшилцөлд хүрэхэд саад болсон асуудлуудыг шийдвэрлэхэд том өөрчлөлт гаргаж чадаагүй байна. Гэсэн хэдий ч энхүү хурал АНУ-ын ерөнхийлөгчөөр Жорж Буш сонгогдон 3 сард АНУ Киотогийн протоколыг дагаж мөрдөхөөс татгалзсанаас хойш зохион байгуулагдсан учир АНУ-ын төлөөлөгч Протоколтой холбоотой аливаа зөвшилцөөнд оролцохоос татгалзаж хуралд ажиглагчийн байр сууринаас оролцсон байна. Бусад талууд ихэнх улс төрийн асуудлууд дээр зөвшилцөлд хүрч чадсан нь хуралаас өмнө ихэнх ажиглагчдын бодож байснаас давсан шийдвэрүүдийг гаргаж чадсан байна. Дараах зүйлүүд дээр зөвшилцөлд хүрч чадсан байна.

1. **Уян хатан механизмууд.** Киотогийн протоколыг анх гарч ирэхэд АНУ-ын хүчтэйгээр дэмжиж байсан энэхүү уян хатан механизмуудад ялгаралын худалдаа,

хамтын хэрэгжүүлэлт болон өндөр хөгжилтэй орнуудын хөгжиж буй орнуудын нутаг дэвсгэрт бууруулж өөрийн дотооддоо бууруулсан мэтээр тооцуулж болох цэвэр хөгжлийн механизм зэрэг багтаж байв. Зөвшилцөлд үүрэг хүлээсэн өндөр хөгжилтэй орнууд нь энэхүү уян хатан механизмуудын тусламжтайгаар худалдан авч болох кредитийн хязгаарыг нарийн заагаагүй бөгөөд зөвхөн өөрсдийн дотооддоо авч хэрэгжүүлж буй алхам нь нилээн чухал байр суурь эзлэнэ гэж тусгажээ.

- 2. Хүлэмжийн хий шингээгч.** Агаар мандлаас хүлэмжийн хийг шингээх болон түүнийг хадгалдаг эх сурвалжууд болох ой, газар тариалангийн менежмент, дахин ургамалжуулах зэрэг үйл ажиллагаанаас кредит цуглуулж болохоор заасан бөгөөд иймэрхүү үйл ажиллагаанаас цуглуулж болох кредитэнд хязгаарлалт тавиагүй байна. Гэвч хавсралт 3т-д орон үүрэг хүлээсэн орон тус бүрт энэхүү үйл ажиллагаанаас цуглуулж болох крепитийг тусгасан байна. Жишээ нь япон улс шингээгчийг нэмэгдүүлэх төслөөс 13 сая тонн буюу 1990 оны түвшинийх нь ялгаралын 4 хувьтай тэнцэх хэмжээний кредитийг ийм замаар цуглуулж болохоор тусгажээ. Газар тариалангийн менежментээс улс орнууд зөвхөн 1990 оны түвшинөөс дээш шингээгчийг нэмэгдүүлсэн тохиолдолд л кредит цуглуулах боломжтой байна.
- 3. Дагаж мөрдөх.** Протоколыг дагаж мөрдөөгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ механизмудыг 7-р бага хуралаар хэлцэн тохиролцооор хойшлуулсан ч дагаж мөрдөөгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх ерөнхий алхамуудыг тусгасан байна. Эдгээр нь бууруулаагүй ХХ-ийн тонн тутмыг 1.3-аар тооцон нэмэгдүүлэх, нэмэлт ялгаралын бууралтыг худалдаалах эрхийг нь тэдгэлзүүлэх, үүргээ биелүүлээгүй орнуудад дагаж мөрдөх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах зэрэг болно.
- 4. Санхүүжилт.** Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авахад тус дэм болохоор 3 санг байгуулах дээр зөвшилцөлд хүрч чадсан байна. Уур амьсгалын хэмжүүрийг хийх уур амьсгалын өөрчлөлтийн сан, Үндэсний дасан зохицох хөтөлбөрийн үйл ажиллагаанд туслах буурай хөгжилтэй орны сан, ЦХМ-ын орлого болон бусад сайн дурын хандивлалтаас бүрдсэн Киотогийн протоколын дасан зохицох сан зэрэг болно.

Эдгээр шийдвэрүүдийг биелүүлэх үйл ажиллагааны нарийн тодорхо заалтуудыг 7-р бага хурлаар зөвшилцөн баталхаар болгож үлдээжээ.

2001 Талуудын 7-р бага хурал, Марракеч, Морокко

2001 оны 10 сарын 29нөөс 11 сарын 10ны хооронд Морокко улсын Марракеч хотноо талуудын 7-р бага хурал зохион байгуулагдаж Буэнос Айрэсийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гүйцээж улс орнууд протоколыг батламжлах л дутуу болтол үйл ажиллагааны нарийн ширийнийг гүйцээсэн байна. Энэхүү хурлаас гарсан шийдвэрүүдийн эмхтгэлийг Марракечийн гэрээ гэх болжээ. АНУ-ын төлөөлөгч ажиглагчын байр сууриндаа хэвээр үлдэж зөвшилцөлд оролцохоос татгалзсан байна. Бусад орнууд АНУ-ыг эргэн хэлэлцээрт оролцоно гэж найдаж буйгаа илэрхийлээд Протокол хүчин төгөлдөр болоход 1990 оны хүлэмжийн хийн ялгаралын дор хаяж 55 хувийг ялгаруулж байсан орнууд протоколыг батламжилсан байх хэрэгтэй гэж үзэж

буйгаа илэрхийлсэн байна. Протоколыг хүчин төгөлдөр болох хугацааг 2002 он гэж тооцоолсон байна.

Талуудын 7-р бага хурлаар гаргасан гол шийдвэрүүдэд:

- Протоколын талуудын хооронд олон улсын ялгаралын худалдааг хийх болон, ЦХМ-ын мөн хамтын үйл ажиллагааны нарийн зохицуулалтыг
- ХХ-ийн ялгаралаа бууруулах үүргээ сахин биелүүлээгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг –гэхдээ энэхүү арга хэмжээ нь хуулийн дагуу хүчин төгөлдөр байх эсэхийг Протокол хүчин төгөлдөр болсны дараа протоколын талуудаар шийдүүлэхээр хойш тавьсан байна.
- Уян хатан механизмуудын тооцоо бүртгэлийн журам
- Талуудын 8-р бага хурлаар одооны ХХ бууруулах үүрэг нь хангалттай эсэхэд дүн шинжилгээ хийж хөгжиж буй орнуудад ч мөн үүрэг хүлээлгэх эсэх талаар авч хэлэлцэхээр шийдвэрлэсэн байна.

2002 Талуудын 8-р бага хурал, Нью Дэли, Энэтхэг

2002 оны 10 сарын 23-наас 11 сарын 1ны хооронд зохион байгуулагдсан.

2003 Талуудын 9-р бага хурал, Милан, Итали

2003 оны 12 сарын 1-12ны хооронд зохион байгуулагдсан.

2004 Талуудын 10-р бага хурал, Буэнос Айрэс, Аргентин

2004 оны 12 сарын 6-17ны хооронд зохион байгуулагдсан.

2005 Талуудын 11-р бага хурал, Талуудын 1-р уулзалт, Монтриал, Канад

2005 оны 11 сарын 28-наас 12 сарын 9-ний хооронд Канадын Монтриал хотноо зохион байгуулагдсан бөгөөд энэ нь мөн Киотогийн протоколын талуудын анхдугаар уулзалт байсан юм.

Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал

Эрдэмтэд манай дэлхийн уур амьсгал дулаарч буйтай санал нэгддэг. Тухайлбал сүүлийн зуун жилийн хугацаанд гадаргуугийн температурын дундаж 0.5°C өссөн хэмээн тодорхойлжээ. Ихэнх эрдэмтэд дэлхийн дулаарал нь зөвхөн температурын байгалийн хэлбэлзэл бус мөн хүний хүчин зүйлээс үүдэлтэй гэж үздэг. Уур амьсгалын өөрчлөлтийн засгийн газар хоорондын хуралдаанаас (УАЗГХХ) 2100 он гэхэд атмосферийн дундаж температур одоогоос 1.0°C -с 3.5°C -р өснө гэж тооцоолсон. Температурын өөрчлөлт нь дэлхийн өнцөг булан бүрт ижил байхгүй. Дэлхийн дулаарал нь уур амьсгалын өөрчлөлтөнд ихээхэн нөлөөлж зуд, ган, мөсөн шуурга, хар салхи зэрэг гэнэтийн аюултай

үзэгдлүүд ихээр тохиолдох хүчин зүйл болно. Дээр дурдсан байгалийн үзэгдлүүд болон нийт дулаарал нь ой модны амьдрах чадварт муугаар нөлөөлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг бууруулах юм.

Хүлэмжийн хийнүүд, тэдгээрийн эх үүсвэрүүд

Нарны дулаан дэлхийн атмосферт нэвтэрч, нэг бол газар болон далайд шингэж, үгүй бол сансар руу эргээд ойдог. Манай гаригийн атмосфер нь усны уур (H₂O), нүүрсхүчлийн хий (CO₂), (N₂O) болон метан зэрэг байгалийн хийнүүдээс бүрддэг.

Эдгээр хүлэмжийн хийн эх үүсвэрүүдийг үзүүлвэл:

Хүлэмжийн хий(XX)	Эх үүсвэр
CO ₂	Тээврийн хэрэгсэл, цахилгаан эсвэл дулаан үйлдвэрлэхтэй холбоотой fossil fuels-н шаталт; тодорхой үйлдвэрлэлийн процесс, халуун орны ойг тайрах.
N ₂ O	Хөдөө аж ахуй, химийн үйлдвэрлэл, шатаах үйл ажиллагаанууд.
CH ₄	Хөдөө аж ахуй, газрын тос, хийтэй холбоотой үйл ажиллагаа болон хог хаягдлын менежментийн үйл ажиллагаа.
SF ₆ HFCs PFCs	Тодорхой үйлдвэрлэлийн процессууд (хөнгөн цагаан эсвэл магниум-хагас дамжуулагчийн үйлдвэрлэл), шүршигч бодисууд, агааржуулагч болон дулаалгын хөөсөнцөр.

Түүнчлэн хотжилт, ой цэвэрлэх, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа, нийлмэл хийн ялгарал, карбонд суурилсан түлшний шаталтаас ялгарсан хий зэрэг хүний хүчин зүйлээр үүссэн хийнүүд атмосферийн химийн найрлагат нөлөөлдөг. Хүмүүс ихээхэн хэмжээний хүлэмжийн хийг атмосферт илгээдэг бөгөөд тэдгээр нь атмосфер дахь дулааныг тогтоон барих чадавхийг нэмэгдүүлж, атмосферийн нийт температурыг нэмэгдүүлэх үндэс болдог.

Хүлэмжийн хийнүүд нь байгаль дээр оршин байдаг. Гэхдээ дэлхий дээрх тээврийн хэрэгслүүд, үйлдвэрлэл, болон дулааны үйлдвэрлэлд шаардагдах эрчим хүчний 85% -г бий болгодог карбонд суурилсан түлшний шаталтаас үүсэх хийнүүд нь тэдгээр хийн концентрацийг өндөр хэмжээнд хүргэдэг байна. Дэлхийн хүн ам 2060 он гэхэд одоогийнхоос 6 тэрбумаар нэмэгдэн 10 тэрбумд хүрч, тэдний 75% нь хот суурин газарт амьдрах бөгөөд 2050 он гэхэд эрчим хүчний хэрэгцээ 3 дахин нэмэгдэнэ хэмээн тооцоолсон байдаг. 2010 он хүртэл хүлэмжийн хийн ялгарлын ихэнхийг аж үйлдвэр хөгжсөн орнуудаас бий болгох бөгөөд хөгжиж буй орнуудын эрчим хүчний хэрэглээ дэлхийн хэрэглээний 40%-д хүртэл өснө гэж үзэж байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенц

Дэлхийн улс орнууд атмосфер дахь хүлэмжийн хийн концентраци өсч буй явдалд ихээхэн санаа зовинох боллоо. Энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор дэлхийн 150 улс 1992 онд

Нэгдсэн үндэсний байгууллагын уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенцод (НҮБУАӨХК) нэгдэж гарын үсэг зуржээ. Энэхүү конвенц нь 2000 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 1990 оны түвшинд хүргэх сайн дурын, хуулийн хүрээний бус хариуцлагыг агуулсан юм.

1995 онд НҮБУАӨХК-н талууд Берлин хотод Талуудын конференцыг (COP-1) зохион байгуулжээ. Энэ конференцоор хуулиар хүлээх хэмжээ хязгаар буюу аж үйлдвэр хөгжсөн орнуудын (Хавсралт 1 эсвэл Хавсралт Б-н орнууд гэгддэг) хүлээх хүлэмжийн хийн ялгарлыг бууралтыг тодорхойлох протоколыг хэлэлцэхээр тохирсон байна. Энэхүү хэлэлцээ нь 1997 оны 1 дугаар сарын 1-11-ний хооронд Японы Киото хотноо Талуудын 3 дахь уулзалтын (COP-3) үеэр хийгджээ. Энэ хэлэлцээний үр дүнд Нэгдсэн үндэсний байгууллагын уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенцын дагуу Киотогийн протокол төржээ.